



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/541

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 145 дүгээр  
цэцэрлэгийн биет бус хөрөнгө  
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,440,000.0 /нэг сая дөрвөн зуун дөчин мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 145 дугаар цэцэрлэг /Ч.Янжиндулам /-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 3 нэр төрлийн 1,440,000.0 /нэг сая дөрвөн зуун дөчин мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 145 дугаар цэцэрлэг /Ч.Янжиндулам/-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050001513

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
 газрын даргын 2019 оны 145 дугаар  
 сарын 12 өдрийн 0/57 тоот тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 145 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Хөрөнгийн программ /нягтлангийн/	9	ш	1	240,000.00	240,000.00	-	-	ашиглах боломжгүй	устгах
2	Хөрөнгийн программ /няравын/	8	ш	1	400,000.00	400,000.00	-	-	ашиглах боломжгүй	устгах
3	Вэб сайт	7	ш	1	800,000.00	800,000.00	-	-	ашиглах боломжгүй	устгах
<b>Нийт данснаас хасах хөрөнгийн дүн</b>						<b>1,440,000</b>				
Үүнээс: Худалдах хөрөнгө										
Актлах хөрөнгө										
Татан төвлөрүүлэх хөрөнгө										
Худалдсанаас олох орлого										
НӨАУГ-т төвлөрүүлэх /30 %/										